

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 01 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2024 оны 12 дугар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлд төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагтай байхаар зохицуулсан байна.

Хууль санаачлагч Зам, тээврийн яам болон Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн орон тоо болон нөөцийг ашиглан төсөвт дарамт учруулахгүйгээр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газрыг байгуулан үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой гэж үзэж тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг d.parliament.mn цахим хаягт байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төмөр замын тээврийн үйл ажиллагааны талаар Зам, тээврийн яамны баримталж буй бодлого, шийдвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Төмөр замын газрын хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц орон тоо, төсөвт үзүүлэх ачааллыг тооцсон эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Төмөр замын газрыг байгуулахдаа бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй, оновчтой зохион байгуулахад анхаарч, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг эргэн харж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль тогтоомж болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар тогтоолын төслийг дэмжиж байгаа бөгөөд агентлагийг байгуулахдаа татан буугдаж буй Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн албан хаагчдын төрийн албаны ангилал зэрэглэл, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, өсөн нэмэгдсээр байгаа тээврийн хэрэгцээг хангах, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх,

тээврийн сүлжээг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэдлэг чадвартай хүний нөөц бүхий төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулах зүй ёсны шаардлага үүссэн тул тогтоолын төслийг дэмжиж байгаа талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

